

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөггүй болно.....	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	12
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Баянхонгор аймгийн Боловсрол
Соёл, Урлагийн Газрын Дарга
М.Мөнхбат Танаа

Ауд. 02.27 № 1/199

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Боловсрол соёл, урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\ 0000 1140


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Боловсрол, соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга М.Мөнхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.25-наас 2020.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсрол, соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.01.25-ны өдрийн 8 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Боловсрол Соёл урлагийн газар нь Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн боловсрол, соёлын зорилтуудыг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, тэгш боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, багш, ажилтны ёс зүй, хариуцлагыг дээшлүүлж чадавхыг нэмэгдүүлэхэд оршино. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Боловсрол Соёл урлагийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Боловсрол Соёл урлагийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Боловсрол Соёл урлагийн газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acoulas" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Боловсрол Соёл урлагийн газар төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 30 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 30 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр БСУГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "их" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1848075,9 мянган төгрөгөөс тооцон 36961,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 55191,6 мянган төгрөгөөр тооцсон.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Боловсрол Соёл урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16475,5 мянган төгрөгөөр буюу 6,4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	968.15	995.44	27.29
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	143,672.88	137,783.88	(5,889.01)
Үндсэн хөрөнгө	308,016.38	279,247.42	(28,768.96)
Хуримтлагдсан элэгдэл	(192,959.90)	(174,804.77)	(18,155.14)
Нийт хөрөнгө	259,697.51	243,221.97	(16,475.54)
Өр төлбөр	202.17	5,374.70	5,172.53
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	259,495.33	237,847.27	(21,648.06)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	259,697.51	243,221.97	(16,475.54)

Бараа материалын данс буурсан нь 4055,7 мянган төгрөгийн аж ахуйн материал акталж. 1913,2 мянган төгрөгийн хөрөнгийг Боловсрол, соёл, урлагийн газрын дэргэдэх шатрын клуб руу үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 28768,9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд Баянхонгор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 12-р сарын 25-ны өдрийн 131 тоот тогтоолыг үндэслэн 38814,5 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан. БСШУС Яамнаас хөрөнгө оруулалтаар 6305,7 мянган төгрөгийн хөрөнгийн үнэ төлбөргүй авсан, төсвийн хөрөнгөөр 3739,9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд 2061887,1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2051854,3 мянган төгрөг зарцуулж 10032,8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмж 9917,7 мянган төгрөгөөр хэмнэгдсэн.

Нэмэлт санхүүжилтээр дээд шатны байгууллагаас 522474,2 мянга, орон нутгийн төсвөөс 35100,0 мянга, олон улсын байгууллагаас төсөл хөтөлбөрт 63611,0 мянга, хандиваар 50000,0 мянган, орлогоор 1116,3 мянган, нийт 672301,5 мянган төгрөгийг бүртгэл тайланд бүрэн тусгасан байна. Нэмэлт санхүүжилтийн дансаар Хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт 168144,9 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулаагүй үлдэгдэл 3097,7 мянган төгрөгийг БСШУЯ-руу буцаан шилжүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 29 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 26 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар дараах 42739,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2260,8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3097,9 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 37380,3 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

1. Цалингийн зардлаас байгууллагын даргын 2019.12.24-ны өдрийн 49 тоот тушаалаар ажилтнуудад 2260,8 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг баталсан 6 дугаар хавсралт"-ын "Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил" заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов

2. Нэмэлт санхүүжилтийн дансаар Хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт 168144,9 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулаагүй үлдэгдэл 3097,7 мянган төгрөгийг БСШУЯ-руу буцаан төвлөрүүлсэн боловч санхүүгийн тайланд зарцуулснаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1. "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Санхүүгийн тайланд залруулав.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Боловсролын тухай хуулийн 43.1.4, 43.1.7 дахь заалтын дагуу тэтгэмж авах хүмүүсийн мэдээллийг бодитой төлөвлөж БШСУЯамнаас хянагдаж ирсэн жагсаалтын дагуу олгосон эсэхэд хяналт тавихад анхаарах

2.13. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 113 мэдээллийг хугацаанд нь, 32 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	6	8	8		
2	Хагас жил	1	1	1	-	-
3	Улирал бүр	1	4	3	1	-
4	Сар бүр	1	36	33	3	-
	Тухай бүр	7	96	68	28	-
	Нийт	16	145	113	32	

Баянхонгор аймгийн Дотоод аудитын газраас хяналт хийгдэж мэдээллийг засварласнаас 32 мэдээ хоцроосон төлөвт байна.

Худалдан авалттай холбоотой мэдээлэл байхгүй болно.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөггүй болно.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Боловсрол Соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бид Баянхонгор аймгийн Боловсрол Соёл урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлан

1.1. Илрүүлэлт:

Боловсрол, соёл, урлагийн газраас 2019 онд Боловсролын тухай хуулийн 43.1.7-д заасны дагуу хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг тулган шалгахад журмын холбогдох шаардлагыг хангаагүйгээс 5 багшийн 15677,4 мянган төгрөгийн тэтгэмжийг олгоогүйгээс хэмнэлт үүссэн.

Тус хэмнэлтээс 11-р цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан Б.Пүрэвтогоод Шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилласан жилийг нөхөн тооцож 3237,0 мянга, 13-р цэцэрлэгийн ажилтан Б.Чанцалдуламд 2676,0 мянган төгрөгийн нийт 5913,0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Мөн Боловсролын тухай хуулийн 43.1.4-д заасан тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 690399,4 мянган төгрөгийг олгохоор төлөвлөснөөс БСШУЯ-аас 699271,6 мянган төгрөг буюу 8872,2 мянган төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.

Энэ нь журмын шаардлага хангаагүй Хүрээмарал сумын багш Н.Гэрэлмаад 4452,0 мянган төгрөгийг олгогдоогүй, ажилласан жилээс хамаарч 7 хүний 15717,7 мянган төгрөгийг дутуу олгосноос нийт 29035,9 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Тус хэмнэлтээс 10-р цэцэрлэгийн нярав А.Чимэгсайханд 10508,5 мянга, 5-р цэцэрлэгийн багш Р.Буяннэмэхэд 19133,4 мянга /2020 онд төсөвт суугдсаныг урьдчилан хүндэтгэн үзэх шалтгааны улмаас/, жагсаалтад суугдсанаас илүү дүнгээр олгосон 3 хүнд 1825,4 мянган төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг зөрчсөн байна.

Өндөр настны тэтгэмж авсан 41 багш, ажилчдаас 7 багш хөдөлмөрийн гэрээгээр одоо ажиллаж байна.

1.1.2. Эрсдэл:

БСШУСЯ-наас батлаглагдсан төсөв, жагсаалтын дагуу олгохгүй байх, Төрийн албаны тухай хууль зөрчигдөх.

1.1.3 Өгсөн зөвлөмж:

Боловсролын тухай хуулийн 43.1.4, 43.1.7 –д заасан тэтгэмжийн төлөвлөхдөө бодитоор төлөвлөж, БСШУСЯ-наас баталсан жагсаалтын дагуу багш, ажилчдад олгож байх.

Өндөр настны Тэтгэвэрт гарах өргөдлөө өгч хуульд заасан тэтгэмжээ авсан боловч үргэлжлүүлэн ажиллаж буй багш, ажиллагсдын ажлын байрыг хуулийн дагуу зарлаж асуудлыг 2020 оны 1-р улиралд багтаан шийдвэрлэх ба эсвэл хуулийн дагуу олгосон тэтгэмжийг ТШЗ-даар тэтгэмжийн буцаан төсөвт төлүүлж хуулийн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллах.

1.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн.

2. Авлага, өглөгийн данс

2.1.1 Илрүүлэлт

Түрээсийн өглөг 5374,7 мянган төгрөгийн өглөгтэй гарсныг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж 2020 оны төсөвт тусгуулсан. 2019 онд түрээсийн зардал 30683,1 төгрөг буюу дутуу батлагдсан нь өглөг үүсэх шалтгаан болжээ.

9 сард О.Алтанцэцэг мэргэжилтэнд гачилдал гарч 450,0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг 12 сард цалингаас суутган тооцоогүй авлагатай байна.

2.1.2. Эрсдэл

Өмнөх онд авлага, өглөгийн үлдэгдэлтэй гарсан нь тайлант оны төсөв хэмнэгдэж өөр зардалд зарцуулагдаж төсөв хэтрэх

2.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4 дэх заалтыг хэрэгжүүлэн өглөг, авлага үүсгэхгүй ажиллах

Цалингийн урьдчилгаа 450,0 мянган төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	144,641,032.53	138,779,314.53
33	АВЛАГА	968,150.21	995,437.21
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	100,000.00	450,000.00
335	Бусад авлага	868,150.21	545,437.21
3351	Байгууллагаас авах авлага	868,150.21	545,437.21
35	БАРАА МАТЕРИАЛ	143,672,882.32	137,783,877.32
351	Түүхий эд материал	135,000.00	135,000.00
35110	Тусгай зориулалттай материал	135,000.00	135,000.00
354	Хангамжийн материал	143,537,882.32	137,648,877.32
35410	Бичиг хэргийн материал	1,535,110.00	1,277,110.00
35420	Аж ахуйн материал	139,178,136.32	134,494,131.32
35430	Сэлбэг хэрэгсэл	2,292,000.00	1,345,000.00
35470	Бусад хангамжийн материал	532,636.00	532,636.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	115,056,474.67	104,442,655.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	115,056,474.67	104,442,655.61
392	Биет хөрөнгө	60,122,474.67	49,247,405.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	11,351,900.00	8,267,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,351,900.00	-8,267,100.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,005,075.00	55,005,075.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-55,005,075.00	-55,005,075.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	122,764,792.53	105,314,478.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-99,922,466.32	-80,849,438.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,594,139.96	19,300,298.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,285,543.42	-14,279,971.35
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,921,566.00	31,706,566.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,515,916.58	-14,510,429.94
39217	Ном	2,565,902.50	2,565,902.50
393	Биет бус хөрөнгө	54,934,000.00	55,195,250.01
39301	Програм хангамж	1,879,000.00	2,154,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,879,000.00	-1,892,749.99
39303	Бусад биет бус хөрөнгө	54,934,000.00	54,934,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	259,697,507.20	243,221,970.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	202,173.18	5,374,700.18
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	202,173.18	5,374,700.18
413	Өглөг	202,173.18	5,374,700.18
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	202,173.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.18	5,374,700.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	259,495,334.02	237,847,269.96
51	Засгийн газрын хувь оролцоо	259,495,334.02	237,847,269.96
511	Засгийн газрын оруулсан капитал/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	260,916,977.83	260,916,977.83
51101	Өмч: - төрийн	260,916,977.83	260,916,977.83
512	Хуримтлагдсан үр дүн	-19,244,360.95	-40,892,425.01
51210	Өмнөх үеийн үр дүн	-19,244,360.95	-19,244,360.95
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-21,648,064.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,822,717.14	17,822,717.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	259,697,507.20	243,221,970.14

3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,171,552,290.61	2,739,377,967.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	128,301,186.60	6,305,679.00
120	Нийтлэг татварын бус орлого	128,301,186.60	6,305,679.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	128,301,186.60	6,305,679.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,569,376.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	126,731,810.60	6,305,679.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,043,251,104.01	2,733,072,288.89
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	308,634,500.00	2,061,887,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	308,634,500.00	2,061,887,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	712,458,604.01	671,185,188.89
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	130,224,250.00	63,611,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	85,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	582,234,354.01	522,474,188.89
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	22,158,000.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	22,158,000.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,070,780,925.17	2,759,580,317.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,070,780,925.17	2,759,580,317.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,070,172,554.17	2,759,580,317.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	213,883,429.00	240,373,706.00
210101	Үндсэн цалин	213,883,429.00	240,273,706.00
210104	Урамшуулал	00.00	100,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,767,398.00	29,902,054.00
210201	Тэтгэврийн даатгал	24,076,220.00	25,144,454.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,649,795.00	1,189,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	951,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	237,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	41,383.00	2,378,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,006,810.00	39,600,000.00
210302	Түлш, халаалт	399,834.00	00.00
210304	Байрны түрээс	30,606,976.00	39,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	90,799,386.00	92,060,655.00
210401	Бичиг хэрэг	15,270,690.00	13,015,338.00
210402	Тээвэр, шатахуун	17,256,730.00	8,554,150.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	226,100.00	407,500.00
210404	Ном, хэвлэл	00.00	18,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	45,600.00	45,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	58,000,266.00	70,020,067.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	520,000.00	2,666,810.00
210604	Урсгал засвар	520,000.00	2,666,810.00
2107	Томилолт, зочны зардал	3,795,500.00	3,789,500.00
210701	Гадаад албан томилолт	482,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	3,313,500.00	3,789,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хугаамж	155,755,688.31	597,947,251.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	155,755,688.31	597,947,251.75

Боловсрол, соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	548,644,342.86	27,335,173.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	515,290,289.70	90,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	3,491,400.00	8,031,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрогдол	29,862,653.16	19,213,673.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	608,371.00	1,725,905,167.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,712,774,409.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	699,271,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	1,012,502,809.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	608,371.00	13,130,758.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,367.00	10,032,841.00
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	522,004.00	3,097,917.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	100,771,365.44	-20,202,349.73
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,700,000.00	1,445,714.33
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,700,000.00	1,445,714.33
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-3,700,000.00	-1,445,714.33
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	97,071,365.44	-21,648,064.06

3.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,044,646,904.01	2,734,188,588.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,500.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	75,500.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	75,500.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	75,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,044,571,404.01	2,734,188,588.89
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	308,634,500.00	2,061,887,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	308,634,500.00	2,061,887,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	713,778,904.01	672,301,488.89
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	130,224,250.00	113,611,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	35,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	582,234,354.01	522,474,188.89
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,320,300.00	1,116,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,158,000.00	00.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	22,158,000.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,037,533,004.01	2,730,448,698.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,037,533,004.01	2,730,448,698.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,037,533,004.01	2,730,448,698.89

Боловсрол, соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,329,600.00	240,770,720.00
210101	Үндсэн цалин	173,612,300.00	177,697,220.00
210102	Нэмэгдэл	28,045,300.00	48,105,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,672,000.00	12,672,000.00
210104	Урамшуулал	00.00	2,296,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,719,600.00	29,734,500.00
210201	Тэтгэврийн даатгал	18,092,249.00	20,219,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,939,848.00	2,378,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,537,924.00	1,903,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	465,197.00	475,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,684,382.00	4,757,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,683,100.00	30,683,100.00
210302	Түлш, халаалт	399,834.00	00.00
210304	Байрны түрээс	30,283,266.00	30,683,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,859,490.00	5,859,830.00
210401	Бичиг хэрэг	2,198,990.00	832,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,765,000.00	2,598,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	226,100.00	641,500.00
210404	Ном, хэвлэл	00.00	171,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	340,600.00	470,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	328,800.00	1,145,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,795,500.00	3,789,500.00
210702	Дотоод албан томилолт	3,795,500.00	3,789,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	191,984,108.31	672,434,881.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	191,984,108.31	672,434,881.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	562,553,234.70	19,271,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	543,553,329.70	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,999,905.00	18,771,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	608,371.00	1,725,905,167.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,712,774,409.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	699,271,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	1,012,502,809.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	608,371.00	13,130,758.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,367.00	10,032,841.00
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	522,004.00	3,097,917.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,113,900.00	3,739,890.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,113,900.00	3,739,890.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,113,900.00	3,739,890.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,113,900.00	3,739,890.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,113,900.00	3,739,890.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-7,113,900.00	-3,739,890.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,982,977.83	17,822,717.14	-116,315,726.39	107,489,968.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,982,977.83	17,822,717.14	-116,315,726.39	107,489,968.58
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	54,934,000.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	0	00.00	97,071,365.44	152,005,365.44
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	260,916,977.83	17,822,717.14	-19,244,360.95	259,495,334.02
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	260,916,977.83	17,822,717.14	-19,244,360.95	259,495,334.02
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	260,916,977.83	17,822,717.14	-19,244,360.95	259,495,334.02
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-21,648,064.06	-21,648,064.06
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	260,916,977.83	17,822,717.14	-40,892,425.01	237,847,269.96

3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,061,887,100.00	2,051,854,259.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,061,887,100.00	2,051,854,259.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	339,195,000.00	339,079,850.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,875,200.00	240,770,720.00
210101	Үндсэн цалин	175,705,400.00	177,697,220.00
210102	Нэмэгдэл	48,105,200.00	48,105,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,672,000.00	12,672,000.00
210104	Урамшуулал	4,392,600.00	2,296,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,734,500.00	29,734,500.00
210201	Тэтгэврийн даатгал	20,219,400.00	20,219,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,378,800.00	2,378,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	475,800.00	1,903,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,903,000.00	475,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,757,500.00	4,757,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,683,100.00	30,683,100.00
210304	Байрны түрээс	30,683,100.00	30,683,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,860,000.00	5,859,830.00
210401	Бичиг хэрэг	720,000.00	832,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	2,598,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	840,000.00	641,500.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	171,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	470,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	1,145,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,800,000.00	3,789,500.00
210702	Дотоод албан томилолт	3,800,000.00	3,789,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,742,200.00	6,742,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,742,200.00	6,742,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19500000.00	19500000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	500,000.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,000,000.00	19,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1722692100.00	1712774409.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,722,692,100.00	1,712,774,409.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	699,271,600.00	699,271,600.00
213208	Ходөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,022,420,500.00	1,012,502,809.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,061,887,100.00	2,051,854,259.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,061,887,100.00	2,051,854,259.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,061,887,100.00	2,051,854,259.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.00	20.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00

3.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийг төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эмний үлдэгдэл	0	0
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0	669,203,571.75
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	0	669,203,571.75
210	Бараа, үйлчилгээний зардал	0	669,203,571.75
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	0	669,203,571.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	669,203,571.75
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	669,203,571.75
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	669,203,571.75
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	113,611,000.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	35,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	519,376,271.75
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,116,300.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАТАЛГААЖУУДСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

ОГНОО: 2020.02.25

ХЯНАСАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

ОГНОО 2020.02.25

ТАЙЛАН БИЧЭГН АУДИТОР

М.АЛТАНТУЯА

ОГНОО 2020.02.25

841714544
БН04000079007423